



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/94

Бсөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор элэгний вирусын илрүүлэг оношилгоонд шаардагдах, урвалж бодисыг худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Я.Жаргалцэцэг (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүдэд: Ё. Нарангарав (Хөндлөнгийн төлөөлөл)
(тохиролцсоноор)

Нарийн бичиг: Д. Нарандулам (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулж, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Я.Жаргалцэцэг)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

C:\My document ZAX A-4

8200010432

